ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА,
ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ЯАМ

БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСЛИЙН МАГАДЛАЛЫН ДҮГНЭЛТИЙН НЭГТГЭЛ

2025 оны 05 дугаар сарын 01 Дугаар 0396/2025 Улаанбаатар хот

Барилга байгууламжийн байршил:	Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын 1 дүгээр баг
Барилга байгууламжийн нэр, зориулалт:	Говь-Алтай аймгийн төвийн "Ариутгах татуургын шугам сүлжээг хэсэгчлэн солих" ажлын зураг, төсөв
Зураг төслийн шифр:	**ABU-04/25**
Хувилбар:	Газар хөдлөлтийн эрчим **8** балл Гадна агаарын тооцооны температур: **-31.3**°C
Хүчин чадал:	- Гадна ариутгах татуургын шугамын ажил: L=1720,0м
Захиалагч:	Говь-Алтай аймгийн Засаг даргын Тамгын газар
Санхүүжилтийн эх үүсвэр:	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар
Зураг төслийн ерөнхий гүйцэтгэгчийн нэр:	"Алтан босгот өргөө" ХХК
Регистрийн дугаар:	6269648
Тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаа:	2025.11.04
Ажлын төрөл:	ЗТ-3.4, ЗТ-3.5, ЗТ-6.1, ЗТ-6.2, ЗТ-7.2, ЗТ-10.2 заалтын дагуу
Зураг төсөл боловсруулах даалгавар баталсан албан тушаалтан, огноо, дугаар:	Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын Ерөнхий архитекторын баталсан 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн ЗД/2025-03 дугаартай зураг төсөл боловсруулах даалгавар
Зураг төсөл боловсруулах гэрээ баталсан албан тушаалтан, огноо, дугаар:	Говь-Алтай аймгийн Засаг даргын Тамгын газар, "Алтан босгот өргөө" ХХК нарын хооронд байгуулсан 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн АЗДТГ-01/2025 дугаартай зураг төсөл боловсруулах гэрээ

Зөвшилцсөн байгууллагууд:

Говь-Алтай аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилга хот байгуулалтын хэлтсийн дарга бөгөөд аймгийн Ерөнхий архитектор	Б.Бямбадорж
Говь-Алтай аймгийн Онцгой байдлын газрын дарга, Хурандаа	Ц.Лувсанжамц
Говь-Алтай аймгийн Эрүүл мэндийн газрын дарга	О.Баатарчулуун
Говь-Алтай аймгийн Засаг дарга	Г.Чинбат
"Ундарга-Алтай" ТТЭҮГ-ын ерөнхий инженер	Г.Хүрэлхүү
"Мэдээлэл холбоо сүлжээ" ХХК-ийн ерөнхий инженер	Д.Цэвэлмаа

"Алтай-Улиастайн эрчим хүчний систем" ТӨХК-ийн ерөнхий инженер			Х.Биндэрьяа
Барилга байгууламжийн зураг төслийн бүрдэл:			
Зураг төслийн бүрдэл:	Зураг төсөл		Магадлал хийсэн экспертийн нэр
	Гүйцэтгэсэн байгууллага:	Шалгасан архитектор, инженер	
Гадна ариутгах татуурга:	"Алтан босгот өргөө" ХХК	С.Ууганцэцэг	Ө.Цэдэндамба
Гадна инженерийн шугам сүлжээний төсөв:	"Алтан босгот өргөө" ХХК	Г.Сондномсүрэн	А.Эрдэнэчимэг
Инженер геологи:	"Буурь суурь" ХХК	Г.Батзориг	Ю.Энхсайхан
Архивын дугаар:	2025/007		
Зураг төсөлд магадлал хийсэн экспертүүдээс зөвшөөрсөн **2**, татгалзсан эксперт байхгүй байна.			

Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт хийгдэх Говь-Алтай аймгийн төвийн "Ариутгах татуургын шугам сүлжээг хэсэгчлэн солих" ажлын төсөвт өртгийн задаргаа

№	Тодорхойлолт	Төсөвт өртөг /төг/	Хүчин чадал /м/	Нэгж өртөг /төг/
1	**Гадна ариутгах татуургын шугамын ажил:**			
АТ	Ариутгах татуургын шугам-1530,72м /Ф200-Ф300мм/	1,580,792,880	1720,0	919,066
Хэсгийн дүн:		**1,580,792,880**		
2	**Гадна тохижилтын ажил:**			
ГТ	Нөхөн сэргээлтийн ажил /явган зам-3236,04м^2; модон хашаа 97,0м^2; гэрэлтүүлгийн шон-22ш/	554,721,993	3236,0	171,420
Хэсгийн дүн:		**554,721,993**		
3	**Зураг төслийн үнэ:**			
ТТ	Зураг төслийн үнэ	20,000,000		
Хэсгийн дүн:		**20,000,000**		
	Төсөвт өртгийн нэгдсэн товчоо			
1	**Гадна ариутгах татуургын шугамын ажил**	**1,580,792,880**		
2	**Гадна тохижилтын ажил**	**554,721,993**		
3	**Зураг төслийн үнэ**	**20,000,000**		
НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:				**2,155,514,873**

Төсөв:
Эксперт нь: Говь-Алтай аймгийн 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт хийгдэх "Ариутгах татуургын шугам сүлжээг хэсэгчлэн солих" ажлын төсөвт өртгийг **2,155,514,873** /хоёр тэрбум нэг зуун тавин таван сая таван зуун арван дөрвөн мянга найман зуун далан гурван/ төгрөгөөр хянасан байна.

Монгол улсын хууль "Барилгын тухай" /шинэчилсэн найруулга 2016 он/ 38.1.2-т "барилга байгууламжийн зураг төслийн холбогдох хэсгийг боловсруулсан зохиогч тухайн зураг төслийг баталгаажуулан, мэргэжлийн хариуцлага хүлээх", 38.1.3-т "зураг төсөл зохиогч хуулийн этгээд барилга байгууламжийн зураг төслийг хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийн шаардлагад нийцсэн эсэхэд хяналт хийж баталгаажуулан, хариуцлага хүлээх", 39.4-т "Эксперт барилга байгууламжийн зураг төслийн холбогдох хэсэгт магадлалын дүгнэлт гаргаж, мэргэжлийн хариуцлага хүлээнэ", 39.5-д "Экспертийн эрх бүхий хуулийн этгээд барилга байгууламжийн зураг төслийг хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотолж, техникийн шийдлийн талаарх дүгнэлт гаргаж, хариуцлага хүлээнэ".

Говь-Алтай аймгийн 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт хийгдэх "Ариутгах татуургын шугам сүлжээг хэсэгчлэн солих" ажлын зураг, төсөвт "Барилгын тухай хууль"-ийн 34.1.4, 34.2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны "Төрийн зарим чиг үүргийг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх тухай" 51 дүгээр тогтоол, 2019 оны 108 дугаар тогтоолоор батлагдсан "Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм"-ийг тус тус үндэслэн магадлал хийх ажлыг зохион байгуулж, экспертүүдийн дүгнэлтийг нэгтгэн бүртгэлийн дугаар олгов.

Дүгнэлтийн нэгтгэл нь экспертүүдийн **4** хуудас магадлалын дүгнэлтийн хамт хүчинтэй.

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛД МАГАДЛАЛ ХИЙХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛСАН

БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ЗАХИРАЛ	Т.ПҮРЭВХАТАН
БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР	З.ЭНХ-ОРГИЛ
БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСЛИЙН МАГАДЛАЛЫН ХЭЛТСИЙН ДАРГА	Г.МӨНХБОЛД
БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСЛИЙН МАГАДЛАЛЫН ХЭЛТСИЙН АЛБАНЫ ДАРГА	М.ЭРДЭНЭБАЯР
БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСЛИЙН МАГАДЛАЛЫН ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН	Т.БАТГЭРЭЛ
БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСЛИЙН МАГАДЛАЛЫН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН	О.БАДАМХОРОЛ

Барилгын хөгжлийн төвийн захирлын тушаал
Дугаар.....
Хавсралт 1

Барилгын хөгжлийн төв
Барилга, байгууламжийн зураг төслийн баримт бичгийн
МАГАДЛАЛЫН НЭГТГЭСЭН ДҮГНЭЛТИЙН ХАВСРАЛТ №1

Барилга, байгууламжийн зураг төслийн бүрдэл хэсгийн нэр /**Гадна инженерийн шугам сүлжээний төсөв:**/
Аймгийн төвийн ариутгах татуургын шугам сүлжээг хэсэгчлэн солих ажлын зураг, төсөв

2025 оны 04 сарын 22 өдөр

Д/д	Утга	Тайлбар
1	Барилга байгууламжийн нэр	Аймгийн төвийн ариутгах татуургын шугам сүлжээг хэсэгчлэн солих ажлын зураг, төсөв
2	Барилга байгууламжийн байршил, хүчин чадал	Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум, 1-р баг
3	Зураг төслийн байгууллага	"Алтан босгот өргөө" ХХК
4	Зургийн шифр	
5	Хуудасны тоо	
6. Дүгнэлтийн товч утга: /Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоос/		
1	6.12.1. архитектур төлөвлөлтийн болон зургийн даалгавар, загвар зураг, эх загвар зураг/эскиз/, байгаль, цаг уурын ерөнхий өгөгдлүүдийг тодорхойлсон, техникийн нөхцөлтэй эсэх;	
2	6.12.2. холбогдох мэргэжлийн байгууллагаар энэ дүрмийн 5.2-т заасны дагуу хянуулж, дүгнэлт гаргуулж баталгаажуулсан эсэх;	
3	6.12.3. барилга байгууламжийн архитектур төлөвлөлт, барилга бүтээц, инженерийн хангамжийн шийдэл нь норм, нормативын баримт бичиг, технологийн даалгавар, тоног төхөөрөмжийн паспорт, инженер геологийн судалгааны дүгнэлт, техникийн нөхцлийн дагуу боловсруулсан эсэх;	
4	6.12.4. хөдөлмөрийн аюулгүй байдал, техник технологийн аюулгүй ажиллагаа, орчны эрүүл ахуйн норм, нормативын баримт бичгийн шаардлагыг хангуулсан эсэх;	
5	6.12.5. барилгын ажлын талбай, үйлдвэрлэлийн зохион байгуулалтын зураг төсөлд хөдөлмөрийн аюулгүй байдал, техник технологийн аюулгүй ажиллагааны нөхцөл шаардлагыг тусгасан эсэх;	
6	6.12.6. инженерийн хангамжийн хувилбар, харьцуулсан тооцоо, сонгосон хувилбарын талаарх дүгнэлттэй эсэх;	
7	6.12.7. хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ, техникийн шаардлагыг хангуулсан эсэх;	
8	6.12.8. эдийн засгийн үр ашиг, экологийн хор хөнөөлгүй байдал, ашиглалтын үеийн найдвартай ажиллагаа, барилга байгууламжийн нийгмийн ач холбогдол зэргийг харгалзан хөрөнгө оруулалтын үр ашгийн талаарх дүгнэлт гаргасан эсэх;	
9	6.12.9. зураг төслийн сонгосон шийдэл, магадлал хийх явцад экспертээс өгсөн нэмэлт, өөрчлөлтийн саналыг зураг төсөлд тусгасан эсэх.	" Алтайн босгот өргөө " ХХК-д боловсруулсан ажлын зургаар мэргэшсэн төсөвчин Г. Содномсүрэн төсөвт өртгийг 2 676 249 446 ₮-гэж тооцсон байна. Магадлал хийх явцад гарсан санал зөвлөмжийг хавсралтад тусгав.

Дүгнэлт бичсэн
Эксперт № 9-25 А.Эрдэнэчимэг /...../

2025 оны 04 сарын 22 өдөр

Зураг төслийн баримт бичгийн
МАГАДЛАЛЫН НЭГТГЭСЭН ДҮГНЭЛТИЙН ХАВСРАЛТ №2

ЗУРАГ ТӨСЛИЙН БҮРДЭЛ ХЭСГИЙН НЭР

Аймгийн төвийн ариутгах татуургын шугам сүлжээг хэсэгчлэн солих ажлын зураг, төсөв

2025 оны 04 сарын 22 өдөр

Д/д	Экспертийн санал, илэрсэн алдаа зөрчил	Биелэлт
1	1. Хөрсний бэхэлгээ хийх, ус соруулах зардал тооцох. 2. Овойлтгүй хөрс солих ажлын үнэлгээг 01-170-с сонгосоныг хянаж үзкэх. 3. Шугамын угсралтыг 16-р бүлгээс, гэр бүрхүүл ган хоолойг 23-р бүлгээс сонгосныг хянаж үзэх. 4. Өрлөгийн зуурмаг бэлтгэх зардал тооцох 5. Зам талбай эвдэх, зөөж хаях болон сэргээж буй асфальто бетон, бетон замын суурь хийх зардал тооцох. 6. Хайрга, элс хайрганы хольц, явган замын хавтан, асфальто бетон зэрэг материалын тээврийн зай хэмжээг хянаж үзэх.	1. Хөрсний бэхэлгээ хийх ажил мөн сувгийн ус соруулах зардал оруулж тооцсон. 2. Овойлтгүй хөрс солих ажлын үндэслэлийг хянаж үзээд үлүү гарсан хөрсөөр солино гэж үзээд хасаж тооцов. 3. Шугам угсралтын ажлын үндэслэлийг хянаж үзээд 22-250 үндэслэлээр бохирын шугамыг, 21-050 ган бүрхэвчийг авч засав. 4. Зуурмаг бэлдэх ажлын зардлыг оруулав. 5. Нөхөн сэргээлтийн буулгалтын ажлын зардлыг оруулав. 6. Хайрга элс хайрганы хольц явган замын хавтан зэргийн материалын тээврийн зайг засаж оруулаа.

Дүгнэлт бичиж, биелэлтийг шалгасан эксперт № 9-25 ..... /А.Эрдэнэчимэг/

..... оны ..... сарын ..... өдөр

Биелэлтийн тайлбар бичсэн ..... /Г.Содномсүрэн/

2025 оны 04 сарын 22 өдөр

МОНГОЛ УЛС
Ганболдын
СОДНОМСҮРЭН
МЭРГЭШСЭН ТӨСӨВЧИН
Т-УДХШС
2024-2027

Барилгын хөгжлийн төвийн захирлын тушаал
Дугаар.....
Хавсралт 1

Барилгын хөгжлийн төв
Барилга, байгууламжийн зураг төслийн баримт бичгийн
МАГАДЛАЛЫН НЭГТГЭСЭН ДҮГНЭЛТИЙН ХАВСРАЛТ №1

Барилга, байгууламжийн зураг төслийн бүрдэл хэсгийн нэр **/Гадна ус хангамж, ариутгах татуурга:/**
Аймгийн төвийн ариутгах татуургын шугам сүлжээг хэсэгчлэн солих ажлын зураг, төсөв

2025 оны 04 сарын 20 өдөр

Д/д	Утга	Тайлбар
1	Барилга байгууламжийн нэр	Аймгийн төвийн ариутгах татуургын шугам сүлжээг хэсэгчлэн солих ажлын зураг, төсөв
2	Барилга байгууламжийн байршил, хүчин чадал	Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум, 1-р баг
3	Зураг төслийн байгууллага	"Алтан босгот өргөө" ХХК
4	Зургийн шифр	ЕГ Шифр: ABU-04/25
5	Хуудасны тоо	69
6. Дүгнэлтийн товч утга: /Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоос/		
1	6.12.1. архитектур төлөвлөлтийн болон зургийн даалгавар, загвар зураг, эх загвар зураг/эскиз/, байгаль, цаг уурын ерөнхий өгөгдлүүдийг тодорхойлсон, техникийн нөхцөлтэй эсэх;	Говь-Алтай аймгийн ерөнхий архитекторын 2025.01.24-ний өдөр баталсан ЗД /2025-03 дугаар бүхий зураг төсөл боловсруулах даалгавартай. **Ажлын даалгаварын 7 болон 12-т заасан нөхцөл шаардлагыг зураг төсөлд бүрэн тусгасан эсэхийг тодотгох**
2	6.12.2. холбогдох мэргэжлийн байгууллагаар энэ дүрмийн 5.2-т заасны дагуу хянуулж, дүгнэлт гаргуулж баталгаажуулсан эсэх;	Говь-Алтай аймгийн Засаг дарга. Онцгой байдлын газар,Эрүүл мэндийн газрын дарга нар зураг төслийн нүүр хуудсан дээр гарын үсэг зурж баталгаажуулсан байна. Зураг төслийн шугамын байгуулалт/ АТГ-4 / дээр холбогдох мэргэжлийн байгууллагаар хянуулж зөвшилцөж баталгаажуулсан байна.

Д/д	Утга	Тайлбар
3	6.12.3. барилга байгууламжийн архитектур төлөвлөлт, барилга бүтээц, инженерийн хангамжийн шийдэл нь норм, нормативын баримт бичиг, технологийн даалгавар, тоног төхөөрөмжийн паспорт, инженер геологийн судалгааны дүгнэлт, техникийн нөхцлийн дагуу боловсруулсан эсэх;	Зураг төслийг БНбД40-01-14, MNS 3241: 2003 болон холбогдох норм дүрэм, зураг төсөл боловсруулах ажлын даалгаварт тусгагдсан нөхцөл, шаардлагад нийцүүлэн хянаж дүгнэлт гаргав. “ Буурь хөрс” ХХК-ийн боловсруулсан ЗТ16-414/22 дугаартай, Архив № 2025 /007 дугаар бүхий төслийн талбайн инженер хайгуулын судалгааны дүгнэлтийг зураг төсөл боловсруулахад ашигласан байна. **Энэхүү дүгнэлтээр төслийн талбай Инженер- геологийн хүнд нөхцөлтэй гэж тодорхойлсон байх тул зураг төсөлд дахин нэмэлт арга хэмжээ тусгах шаардлага байгаа эсэхийг дахин нягталж үзэхийг зөвлөж байна.** Зураг төсөл боловсруулалтын шаардлага хангана.
4	6.12.4. хөдөлмөрийн аюулгүй байдал, техник технологийн аюулгүй ажиллагаа, орчны эрүүл ахуйн норм, нормативын баримт бичгийн шаардлагыг хангуулсан эсэх;	Зураг төсөлд техникийн болон аюулгүй ажиллагааны нөхцөл шаардлагыг дурьдсан байна.
5	6.12.5. барилгын ажлын талбай, үйлдвэрлэлийн зохион байгуулалтын зураг төсөлд хөдөлмөрийн аюулгүй байдал, техник технологийн аюулгүй ажиллагааны нөхцөл шаардлагыг тусгасан эсэх;	Тайлбар бичигт тодорхой нөхцөл шаардлагыг тусгасан байна
6	6.12.6. инженерийн хангамжийн хувилбар, харьцуулсан тооцоо, сонгосон хувилбарын талаарх дүгнэлттэй эсэх;	Харьцуулсан хувилбаргүй
7	6.12.7. хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ, техникийн шаардлагыг хангуулсан эсэх;	-
8	6.12.8. эдийн засгийн үр ашиг, экологийн хор хөнөөлгүй байдал, ашиглалтын үеийн найдвартай ажиллагаа, барилга байгууламжийн нийгмийн ач холбогдол зэргийг харгалзан хөрөнгө оруулалтын үр ашгийн талаарх дүгнэлт гаргасан эсэх;	Дүгнэлтгүй
9	6.12.9. зураг төслийн сонгосон шийдэл, магадлал хийх явцад экспертээс өгсөн нэмэлт, өөрчлөлтийн саналыг зураг төсөлд тусгасан эсэх.	Экспертээс магадлал хийх явцад өгсөн нэмэлт өөрчлөлтийн санал, зөвлөмжийг ажлын зураг төсөлд тусгасан болно. Зураг төслийн шийдлийн угсралтын ажил гүйцэтгэх боломжтой.

Дүгнэлт бичсэн
Эксперт № 6-6 Ө.Цэдэндамба /...../

MONGOLIA TSEDENDAMBA Ulugchuu CONSULTING ENGINEER 02-360

2025 оны 04 сарын 20 өдөр

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАР
ГАЛ ТҮЙМЭРИЙН
УЛСЫН ХЯНАЛТЫН БАЙЦААГЧИЙН
ДҮГНЭЛТ
Баянхайрхан баг, Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82081
Утас/Факс: 7048101, 88049560, 88038818
Цахим шуудан :ontsgoi.2024@gmail.com

2025.02.12 № 040/02

АЛТАН БОСГОТ ӨРГӨӨ
ХХК-Д

Зурагт хяналт хийсэн тухай

Нэг. Барилга байгууламжийн зураг төслийн мэдээлэл:

1. Барилга байгууламжийн байршил: Говь-Алтай аймгийн Есөнбулаг сум
2. Зургийн шифр, зураг төслийн байгууллага: “Алтан Босгот Өргөө” ХХК ABU-04/25
3. Барилга байгууламжийн зориулалт: Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын төвийн ариутгах татуургын шугам сүлжээг хэсэгчлэх солих
4. Барилгын давхар, периметр: 1.5
5. Галд тэсвэршилтийн зэрэг: үгүй
6. Үйлдвэрлэлийн ангилал: үгүй
7. Барилгын үүргийн галын аюулын анги: үгүй
8. Зургийн иж бүрдэл: 1 хэсэг, 14 хуудас
9. Галын аюулгүй байдлыг хангах чиглэлээр:

Барилгын ажлыг гүйцэтгэх. Галын аюулгүй байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх зүйлийг мөрдөх. /Барилга байгууламж, объект шинээр барих, засварлах, хийц, бүтээцийг өөрчлөх, техник тоноглолыг шинэчлэх зураг төслийг зохиоход галын аюулгүй байдлын норм, норматив шаардлагыг дагаж мөрдөнө/

Хоёр: ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

“Алтан босгот Өргөө” ХХК зураг төслийг нь хийсэн Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын төвийн ариутгах татуургын шугам сүлжээний ажлын зураг төсөл нь барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүйн норм БНбД 21-02-02-н шаардлага, Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм БНбД 30.01.04-ийн шаардлагыг хангаж байгаа болно.

Зураг төсөлд өөрчлөлт оруулах тохиолдолд Онцгой байдлын байгууллагатай зөвшилцөж шийдвэрлэнэ.

Сар, өдөр	Тэмдэг дарсан хуудасны дугаарууд	Тэмдэглэл
2025.02.12	Холбогдох хуудсанд тэмдэг дарав.	

ДҮГНЭЛТ ГАРГАСАН:
ГАЛ ТҮЙМРИЙН УЛСЫН ХЯНАЛТЫН БАЙЦААГЧ,
ХОШУУЧ С.ЭНХБАЯР